

Засаг даргын тамгын газарт

2017.05.11

Өлгий сум

Албаны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон Онцгой байдлын газартай хамтран байгуулсан “Онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах төлөвлөгөө”-ний дагуу 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдөр албаны хурлын танхим болон ялтны удаан хугацааны эргэлт, уулзалтын өрөөнд гал гарсан гэх өгөгдлөөр команд штабын сургуулилт зохион байгууллаа.

“Команд штаб”-ын сургуулилтын хүрээнд гал гарсан үед жижүүрийн бүрэлдэхүүний хийж гүйцэтгэх үүрэг, гал унтраагууртай хэрхэн харьцах талаар практик сургалтыг алба хаагч бүрээр хийлгэн хуурай тархалтын дадлага хийлгэсэн.

Уг “Команд штаб”-ын сургалтад албаны бие бүрэлдэхүүн, Онцгой байдлын газраас 1 салаа буюу 7 алба хаагч оролцлоо.





Мөн Шуурхай бүлгийн алба хаагчдын өндрөөс буух ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Онцгой байдлын газрын 4 давхар бүхий цамхагаас буух дадлага сургуулилт хийлгэн ажиллалаа.



ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБА